



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/442


Улаанбаатар хот

Үндэсний шигшээ баг бүрдүүлэх
спортын төрөл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/167 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ын 2.12 дахь хэсэг, "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгон шалгаруулах зөвлөл"-ийн 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад спортын төрлийн спортын холбоодтой холбогдох журмын дагуу гэрээ байгуулан ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга /Ц.Шаравжамц/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын бодлогын газрын дарга /С.Чинбат/-д даалгасугай.

САЙД



Ц.ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний
өдрийн дугаар тушаалын хавсралт



ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГ БҮРДҮҮЛЭХ
СПОРТЫН ТӨРӨЛ

1. Жүдо бөх
2. Чөлөөт бөх
3. Бокс
4. Буудлага
5. Байт харваа
6. Хөнгөн атлетик
7. Олимпийн таеквондо
8. Хүндийн өргөлт
9. Цана
10. Пара жүдо бөх
11. Пара буудлага
12. Пара байт харваа
13. Пара хөнгөн атлетик
14. Пара таеквондо
15. Пара пауерлифтинг
16. Пара гүйлтийн цана
17. Сагсан бөмбөг